” МОНHАБ “ ХК -ний
ТУЗ-н дарга, гишүүд, нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэл

2024 он

| Д/д | Овог нэр | Албан тушаал | ТУЗ-н Хуралд оролцсон | ХЭХуралд оролцсон байдал | ТУЗ н аль нэг хороонд ажилласан байдал | Үнэлгээ /тайлбар/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Р.Зоригт | ТУЗ н дарга | 5 | 1 | 2 | хангалттай |
| 2. | Т.Бадамжунай | ТУЗ н гишүүн | 2 | 1 | 0 | Бүрэн хангалттай биш /өвчтэй байсан/ |
| 3. | Д.Пүрэв | ТУЗ н гишүүн | 2 | 0 | 0 | Бүрэн хангалттай биш /өвчтэй байсан/ |
| 4. | Ш.Оюун-Эрдэнэ | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 5. | Р.Алтанцэцэг | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 6. | Д.Болорцэцэг | ТУЗ н хараат бус гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 7. | Г.Төгөлдөр | ТУЗ н хараат бус гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 8. | Л.Мөнхтуяа | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 9. | Л.Амарсайхан | ТУЗ н хараат бус гишүүн | 4 | 1 | 2 | хангалттай |
| 10. | З.Жаргал | ТУЗ-н нарийн бичиг | 5 | 1 | 2 | хангалттай |

Гүйцэтгэх захирал Ш.Оюун-Эрдэнэ

Батлав: " МОННАБ" ХК -ний
ТУЗ-н Дарга..................................Р.Зоригт

1. ТУЗ-н гишүүний үүргээ гүйцэтгэхэд авах цалин урамшуулалын хэмжээг доорхи үндэслэлүүдийг баримтлан тогтооно.
   1.1 Тогтмол цалин /хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ/цаашид Ххдх гэх /
   1.2 Хуралд оролцсон байдал / Ххдх -ний 10%/
   1.3 ТУЗ н аль нэг хороонд ажилласан нэмэгдэл / Ххдх -ний 10%/
   1.4 Компанийн жилийн үр дүнгээс олгох цалин /тухайн жилд олсон ашгаас тогтооно/
   1.5 Мэргэжлийн өндөр ур чадвар гаргасан Ххдх -ний 10%/

| Д/д | Овог нэр | Тогтмол цалин | Хуралд оролцсон нэмэгдэл | Компанийн жилийн үр дүнгээс олгох цалин | Мэргэжлийн өндөр ур чадвар гаргасан нэмэгдэл | ТУЗ н аль нэг хороонд ажилласан нэмэгдэл |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 2. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 3. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 4. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 5. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 6. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 7. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 8. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 9. | ТУЗ-н гишүүн | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |
| 10. | ТУЗ-н нарийн бичиг | ххдх | Ххдх -ний 10% | тухайн жилд олсон ашгаас тогтооно | Ххдх -ний 10% | Ххдх -ний 10% |

Батлав. ТУЗ-н Дарга........................................Р.Зоригт

2025 онд ТУЗ -н бүрэлдэхүүнийг сургалтанд хамруулах хөтөлбөрийн биелэлт

2025 он ... ....

| | Сургалтын нэр | Хийгдэх хугацаа | Хариуцсан байгууллага, ажилтан | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Чиглүүлэх сургалт | тухай бүр | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | ТУЗ-ийн гишүүд өөрчлөгдөх тохиолдолд шинээр томилогдох ердийн болон хараат бус гишүүдэд зориулсан сургалт |
| 2 | Компанийн ТУЗ-н гишүүдэд зориулсан хууль эрх зүйн сургалт | 6 р сард | Хүний нөөцийн мэргэжилтэн | МҮИС н Хууль зүйн тэнхимийн багш Д.Баатар "Компанийн тухай хууль",Байгууллагын дотоод журмын талаар сургалт явуулав. 2025-06-16 |
| 3 | Удирдах ажилтны сургалт | 12 дугаар сард | Хүний нөөцийн мэргэжилтэн | Компанийн хэмжээнд нийт удирдах ажилтнуудад зориулсан |

## " МОННАБ" ХК -ний ТУЗ-н хурлын тэмдэглэл

"МОН-НАБ" ХК-ийн ТУЗ -н хурал 2025 оны 02 дугээр сарын 18 -ны өдөр Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 6-р хороо Жуулчны гудамж -19, Хишиг төв 7 давхар 701 тоотод болов.

Хурал 16.00 цагаас эхлэж ТУЗ –н дарга Р.Зоригт даргалан явуулав.

ТУЗ -н хуралд

- Т. Бадамжунай
- Р.Зоригт
- Ш.Оюун-Эрдэнэ
- Г.Төгөлдөр
- Д.Болорцэцэг
- Л.Амарсайхан
- Р.Алтанцэцэг
- Л.Мөнхтуяа нар тус тус хүрэлцэн ирж 88% н ирцтэй байна.

Хэлэлцэх асуудал:

- ТУЗ -н 2024 оны ажлын тайланг хэлэлцэж 2025 оны ажлын төлөвлөгөө батлах / төлөвлөгөөг хэвлэж тараасан байгаа тул уншаад санал хэлнэ үү/
- Хувьцаа Эзэмшигчдын ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай
- 2025 оны Хувьцаа Эзэмшигчдын ээлжит хурлын тов ,хэлэлцэх асуудлын жагсаалтыг батлах
- Ноогдол ашиг хуваарлах эсэх тухай хэлэлцэх
- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх

ТУЗ 2024 онд хийсэн ажлын талаар ТУЗ – н дарга Р.Зоригт танилцуулав.
2024 онд бид доорхи ажлыг хийсэн

1. ТУЗ н хурлаа 5 удаа хийсэн тухайн үеийн асуудлаа илэн далангүй ярьсан
2. Санхүүгийн байдлаа яаж сайжруулах талаар 2024 оны 2 р улирлын болон жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргах аудитын байгууллагатай хамтран ажиллаж байгаа.
3. Гадна дулааны шугамын засварын ажлын явц гүйцэтгэл болон манай байгууллагатай тохирсон ажлаа хийж дуусгах талаар" Хажуу ус "ХХК ний удирдлага , инженертэй 2 удаа уулзасан ба нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтнүүд ирж газар дээр нь ажлын явцтай танилцсан .
4. Хувьцаа эзэмшигчдын хурлаа хийж төлөвлөсөн асуудлаа хэлэлцэж баталсан.
5. ТУЗ н хороодууд тус бүрдээ өөрсдийн ажлын тайланг тавьсан байгаа .

Санал хүсэлт:Ш.Оюун-Эрдэнэ: Жилийн ажлын тайлан болон хэлэлцэх асуудалтай санал нэг байна .
Л.Амарсайхан: Санал нэг байна.
Т.Бадамжунай:Дэмжинэ.
Р.Алтанцэцэг: Хэлэлцэх асуудал болон тайлантай санал хэлэхэд санхүүгийн байдлаа цаашид сайжруулахад ажиллах хэрэгтэй байна.

Г.Төгөлдөр : Санал нэг байна.
Д.Болорцэцэг: Дэмжинэ.
Л.Мөнхтуяа : Асуудлыг дэмжинэ.
Р Зоригт: Хэлэцэх асуудалтай санал нэг байна.
дэмжиж байна .

Хурлаас гарсан шийдвэр
Тогтоол:

Монгол улсын "Компанийн тухай хууль"- ийн 60.1 –д заасныг үндэслэн шийдвэрлэх нь:

1. "МОННАБ" ХК-ний хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлыг хуралдуулсугай.
2. "МОННАБ" ХК-ний хувьцаа эзэмшигчдын ээлжит хурлыг 2025-04-03- ний өдрийн 14 цагт Чингэлтэй дүүрэг 6-р хороо Жуулчны гудамж -19, Хишиг төв 7 давхар 701 тоотод хуралдуулсугай .

   Хуралд хэлэлцэх асуудал:
   - Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд ТУЗ-н өгсөн дүгнэлт;
   - ТУЗ-н ажлын тайланг хэлэлцэж батлах;
   - Компанийн үйл ажиллагааны цаашдын зорилтыг хэлэлцэж батлах;
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр
4. 2025-03-10
   - ний өдрөөр тогтоосон болно.
5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр 2025-02-22
   - нд " MONNAB.mn " цахим хуудас , Хөрөнгийн биржийн цахим хуудсаар,
   2025-03-03 , 2025-03-19- ны "Өнөөдөр" сонины дугаарт хэвлүүлэн мэдээлэх болно.
6. Хувьцаа эзэмшигчид ажлын өдрүүдэд 09-16 цагийн хооронд "МОННАБ" ХК-ний байранд ирэх, хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй холбогдон танилцах бичиг баримт :
   - Хурлаар хэлэлцэх асуудал
   - Хурлын шийдвэрийн төсөл
   - Санхүүгийн тайлан,аудитийн дүгнэлт
   - Үйл ажиллагааны тайлан болон бусад бичиг баримтуудтай танилцаж болно.
7. Санал авах сүүлийн өдрийг 2025-04-03- ний өдрөөр тогтоов.
8. Хурлын даргаар Р.Зоригт ажиллана.
9. Хурлын санал хураах тооллогын комиссын дарга гишүүдийг санал хураалтаар сонгон ажиллуулсугай.
10. Хувьцаа эзэмшигчдын хурлын зарыг 2025-03-03, 2025-03-19-ны өдрүүдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Ш.Оюун-Эрдэнэ-д даалгасугай.

11. Компаний үйл ажиллагаа,санхүүгийн байдлын талаар ТУЗ-н өгсөн дүгнэлтийг үндэслэн 2025 онд “МОННАБ” ХК нь ногдол ашиг хуваарлахгүй гэж шийдвэрлэв.

Хурал хэлэлцэх асуудлаа дуусаж хурал хаасныг мэдэгдэв.

ТУЗ- н дарга Р.Зоригт